

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Мөрөн сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2023/104/НА-СТА-ТЗШ

Цахим хуудас:
www.audit.mn

Хөвсгөл аймаг
2022 он

Аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар
Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр
Утас: 99089114 Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Давааням
Утас: 92113932 Цахим хаяг: davaanyamb@audit.gov.mn

Аудитор: Г.Ичинхорлоо
Утас: 88012671 Цахим хаяг: ichinkhorlooga@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Аудитын санал дүгнэлт.....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
3. Аудитын тайлан	9
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	10
3.2 Байгууллагын гадаад дотоод орчин	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	11
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	11
4. АУДИТЫН ТАЙЛАН	13
4.1 Ерөнхий зүйл	13
4.2 Материаллаг байдал	13
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	13
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	14
5. Аудитын илрүүлэлт	15
5.2 Төлбөрийн акт	15
5.3 Албан шаардлага	15
5.4 Зөвлөмж	15
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	15

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

төрийн аудитын газар № 01/96
танай _____-ны № _____-т

МӨРӨН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА Г.НЭРГҮЙ
ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Мөрөн сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөвсгөл аймгийн Мөрөн сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Эзэмших эрх бүхий 172,112 м.кв хэмжээтэй 2,142,291.0 мянган төгрөгийн газрыг эзэмшигчийн өмчийн бусад хэсгээс дүрмийн санд шилжүүлэн бүртгэсэн.

Аудитын гол асуудал

Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт болон орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 866,090.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авсан байна.

Бусад асуудлын хэсэг

Мөрөн сумын Засаг даргатай байгуулсан 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө 94 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшний боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу

илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	115,359,499.47	175,748,133.37
33	АВЛАГА	33,294,139.47	66,274,923.37
33300	Татаас, санхүүжилтийн авлага	32,796,682.37	66,274,923.37
335	Бусад авлага	497,457.10	00.00
3351	Байгууллагаас авах авлага	497,457.10	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	82,065,360.00	109,473,210.00
351	Түүхий эд материал	30,069,710.00	37,590,710.00
35110	Тусгай зориулалттай материал	30,069,710.00	37,590,710.00
354	Хангамжийн материал	51,995,650.00	71,882,500.00
35410	Бичиг хэргийн материал	1,774,100.00	8,894,100.00
35420	Аж ахуйн материал	43,176,050.00	39,188,400.00
35430	Сэлбэг хэрэгсэл	75,000.00	75,000.00
35450	Барилгын засварын материал	2,892,500.00	3,927,000.00
35470	Бусад хангамжийн материал	4,078,000.00	19,798,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	24,385,695,909.73	23,053,572,756.06
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	24,385,695,909.73	23,053,572,756.06
392	Биет хөрөнгө	22,224,312,201.19	20,898,556,547.40
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,695,980,092.51	1,695,980,092.51
39202	Хуримтлагдсан элэгдэл	-207,326,298.17	-259,064,210.89
39203	Авто-тээврийн хэрэгсэл	64,450,000.00	63,299,999.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-47,243,750.01	-37,040,416.83
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	241,165,251.00	520,418,732.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-45,790,938.63	-119,181,788.07
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	82,806,782.00	86,202,060.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-26,932,309.58	-38,518,359.59
39209	Зам, гүүрийн байгууламж	17,846,871,069.11	17,846,871,069.11
39210	Хуримтлагдсан элэгдэл	-3,181,622,468.15	-4,572,808,046.51
39214	Бусад үндсэн хөрөнгө	7,552,122,019.42	7,753,334,046.37
39215	Хуримтлагдсан элэгдэл	-1,982,842,108.31	-2,562,609,489.70
39217	Ном	232,674,860.00	521,672,860.00
393	Биет бус хөрөнгө	2,161,383,708.54	2,155,016,208.66
39301	Програм хангамж	137,500.00	137,500.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-3,819.44	-49,652.72
39303	Бусад биет бус хөрөнгө	2,192,506,000.00	2,192,506,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-31,255,972.02	-37,577,638.62
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	24,501,055,409.20	23,229,320,889.43
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	24,501,055,409.20	23,229,320,889.43
51	Засгийн газрын хувь оролцоо	24,501,055,409.20	23,229,320,889.43
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,594,753,898.45	2,594,753,898.45
51101	Өмч: - төрийн	452,462,898.45	2,594,753,898.45
51106	Эздийн өмчийн бусад хэсэг	2,142,291,000.00	00.00
512	Хуримтлагдсан үр дүн	21,530,010,782.08	20,258,276,262.31
51210	Өмнөх үеийн үр дүн	21,530,010,782.08	21,530,010,782.08
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-1,271,734,519.77
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	376,290,728.67	376,290,728.67
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	24,501,055,409.20	23,229,320,889.43

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
------------	----------	---------------------	-----------------------

Мөрөн сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	10,737,183,701.09	2,353,817,314.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	9,337,843,854.73	1,000,551,533.00
120	Нийтлэг татварын бус орлого	9,337,843,854.73	1,000,551,533.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	9,337,843,854.73	1,000,551,533.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого – Үндсэн хөрөнгө	9,301,861,104.73	952,130,533.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого – бараа материал	35,982,750.0	48,421,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,399,339,846.36	1,353,265,781.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	242,143,846.36	59,989,681.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	158,746,001.36	00.00
131103	ЗГНХ,ЗДНХхөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	40,356,000.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	13,536,847.00	4,331,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	29,504,998.00	55,658,681.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,157,196,000.00	1,293,276,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,157,196,000.00	1,293,276,100.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,506,407,744.38	3,624,570,708.92
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,506,407,744.38	3,624,570,708.92
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,432,999,849.73	3,531,904,518.76
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	630,347,857.96	538,014,663.23
210101	Үндсэн цалин	503,780,763.75	409,860,906.19
210102	Нэмэгдэл	00.00	66,815,393.16
210103	Унаа хоолны хөнгөлөлт	59,595,999.80	41,057,439.88
210104	Урамшуулал	66,971,094.41	20,280,924.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	85,522,728.46	66,106,812.05
210201	Тэтгэврийн даатгал	60,820,048.17	44,832,860.31
210202	Тэтгэмжийн даатгал	6,320,858.59	5,550,835.55
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,056,667.32	4,430,588.41
210204	Ажилгүйдлийн даатгал	1,211,505.06	1,014,285.23
210205	Эрүүл мэндийн даатгал	12,113,649.32	10,278,242.55
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	100,249,338.02	102,182,693.62
210301	Гэрэл, цахилгаан	4,632,247.37	6,608,027.27
210302	Түлш, халаалт	91,098,924.92	91,313,934.36
210303	Цэвэр, бохир ус	4,518,165.73	4,260,731.99
2104	Хангамж, бараа материалын зардал	80,512,199.94	46,960,729.04
210401	Бичиг хэрэг	14,356,100.00	15,638,000.00
210402	Тээвэр, шатахуун	18,443,939.17	15,000,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,132,730.77	5,326,970.04
210404	Ном, хэвлэл	1,079,430.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	31,500,000.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	10,000,000.00	10,995,759.00
2105	Нормативт зардал	2,150,000.00	00.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,150,000.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	38,099,700.00	21,133,150.00
210604	Урсгал засвар	38,099,700.00	21,133,150.00
2107	Томилолт, зочны зардал	2,601,400.00	3,410,700.00
210702	Дотоод албан томилолт	2,346,200.00	1,410,700.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	255,200.00	2,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	178,967,132.00	262,919,211.00

Мөрөн сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	177,820,652.00	258,645,463.00
210803	Даатгалын үйлчилгээ	148,500.00	100,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	183,980.00	249,748.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	132,000.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	682,000.00	3,924,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,314,549,493.35	2,491,176,559.82
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	168,322,638.88	204,200,398.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,930,350.00	2,833,600.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	2,143,296,504.47	2,284,142,561.82
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	73,407,894.65	92,666,190.16
2132	Бусад урсгал шилжүүлэг	29,394,700.00	39,959,837.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	00.00	16,737,312.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	18,447,000.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	10,947,700.00	23,222,525.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	44,013,194.65	52,706,353.16
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	44,013,194.65	52,706,353.16
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	7,230,775,956.72	-1,270,753,394.92
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	398,156,412.80	981,124.85
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	398,156,412.80	981,124.85
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-398,156,412.80	-981,124.85
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	6,832,619,543.92	-1,271,734,519.77

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	641,522,898.45	376,290,728.67	14,697,391,238.16	15,715,204,865.28
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	6,832,619,543.92	00.00
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,594,753,898.45	376,290,728.67	21,530,010,782.08	24,501,055,409.20
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,594,753,898.45	376,290,728.67	21,530,010,782.08	24,501,055,409.20
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-1,271,734,519.77	-1,271,734,519.77
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,594,753,898.45	376,290,728.67	20,258,276,262.31	23,229,320,889.43

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,441,623,089.36	1,386,062,463.37
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,441,623,089.36	1,386,062,463.37
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	284,427,089.36	92,786,363.37
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	158,746,001.36	00.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	40,356,000.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	13,536,847.00	4,331,000.00

Мөрөн сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	71,788,241.00	88,455,363.37
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,157,196,000.00	1,293,276,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,157,196,000.00	1,293,276,100.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,429,239,189.36	1,385,192,463.37
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,429,239,189.36	1,385,192,463.37
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,323,034,612.34	1,226,251,349.84
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	630,347,857.95	538,014,663.23
210101	Үндсэн цалин	503,780,763.74	409,860,906.19
210102	Нэмэгдэл	00.00	66,815,393.16
210103	Унаа хоолны хөнгөлөлт	59,595,999.80	41,057,439.88
210104	Урамшуулал	66,971,094.41	20,280,924.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	85,522,728.46	66,106,812.05
210201	Тэтгэврийн даатгал	60,820,048.17	44,832,860.31
210202	Тэтгэмжийн даатгал	6,320,858.59	5,550,825.55
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,056,667.32	4,430,588.41
210204	Ажилгүйдлийн даатгал	1,211,505.06	1,014,285.23
210205	Эрүүл мэндийн даатгал	12,113,649.32	10,278,252.55
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	100,746,795.12	101,685,236.52
210301	Гэрэл, цахилгаан	4,632,247.37	6,608,027.27
210302	Түлш, халаалт	91,098,924.92	91,313,934.36
210303	Цэвэр, бохир ус	5,015,622.83	3,763,274.89
2104	Хангамж, бараа материалын зардал	79,068,965.77	45,322,729.04
210401	Бичиг хэрэг	12,820,000.00	14,000,000.00
210402	Тээвэр, шатахуун	18,443,205.00	15,000,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,132,730.77	5,326,970.04
210404	Ном, хэвлэл	1,173,030.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	31,500,000.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	10,000,000.00	10,995,759.00
2105	Нормативт зардал	2,150,000.00	00.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,150,000.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	37,499,700.00	21,000,000.00
210604	Урсгал засвар	37,499,700.00	21,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	7,346,200.00	3,410,700.00
210702	Дотоод албан томилолт	2,346,200.00	1,410,700.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	5,000,000.00	2,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	175,675,650.99	262,049,211.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	174,474,170.99	257,775,463.00
210803	Даатгалын үйлчилгээ	148,500.00	100,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	183,980.00	249,748.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	132,000.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	737,000.00	3,924,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	204,676,714.05	188,661,998.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	201,746,364.05	185,828,398.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,930,350.00	2,833,600.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	106,204,577.02	158,941,113.53
2132	Бусад урсгал шилжүүлэг	29,394,700.00	39,959,837.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	00.00	16,737,312.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	18,447,000.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	10,947,700.00	23,222,525.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	76,809,877.02	118,981,276.53

Мөрөн сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	76,809,877.02	118,981,276.53
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	12,383,900.00	870,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	12,383,900.00	870,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	12,383,900.00	870,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	12,383,900.00	870,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	12,383,900.00	870,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-12,383,900.00	-870,000.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	/ төгрөгөөр /		
			Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,293,276,100.0	1,240,569,746.8	52,706,353.2	95.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,293,276,100.0	1,240,569,746.8	52,706,353.2	95.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,245,214,100.0	1,204,759,909.8	40,454,190.2	96.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	553,513,700.0	538,014,663.2	15,499,036.8	97.2
210101	Үндсэн цалин	492,275,100.0	409,860,906.2	82,414,193.8	83.3
210102	Нэмэгдэл	00.0	66,815,393.2	-66,815,393.2	
210103	Унаа хоолны хөнгөлөлт	61,238,600.0	41,057,439.9	20,181,160.1	67.0
210104	Урамшуулал	00.0	20,280,924.0	-20,280,924.0	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	68,202,600.0	66,106,812.1	2,095,788.0	96.9
210201	Тэтгэврийн даатгал	46,396,300.0	44,832,860.3	1,563,439.7	96.6
210202	Тэтгэмжийн даатгал	6,101,500.0	5,550,825.6	550,674.5	91.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,187,900.0	4,430,588.4	-242,688.4	105.8
210204	Ажилгүйдлийн даатгал	1,046,900.0	1,014,285.2	32,614.8	96.9
210205	Эрүүл мэндийн даатгал	10,470,000.0	10,278,252.6	191,747.4	98.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	104,642,600.0	101,685,236.5	2,957,363.5	97.2
210301	Гэрэл, цахилгаан	8,000,000.0	6,608,027.3	1,391,972.7	82.6
210302	Түлш, халаалт	91,642,600.0	91,313,934.4	328,665.6	99.6
210303	Цэвэр, бохир ус	5,000,000.0	3,763,274.9	1,236,725.1	75.3
2104	Хангамж, бараа материалын зардал	45,700,000.0	45,322,729.0	377,271.0	99.2
210401	Бичиг хэрэг	14,000,000.0	14,000,000.0	00.0	100.0
210402	Тээвэр, шатахуун	15,000,000.0	15,000,000.0	00.0	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,500,000.0	5,326,970.0	173,030.0	96.9
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	11,200,000.0	10,995,759.0	204,241.0	98.2
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	21,000,000.0	21,000,000.0	00.0	100.0
210604	Урсгал засвар	21,000,000.0	21,000,000.0	00.0	100.0
2107	Томиллолт, зочны зардал	4,000,000.0	3,410,700.0	589,300.0	85.3
210702	Дотоод албан томиллолт	2,000,000.0	1,410,700.0	589,300.0	70.5
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	2,000,000.0	2,000,000.0	00.0	100.0

Мөрөн сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	249,515,200.0	240,557,771.0	8,957,429.0	96.4
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	244,295,200.0	236,284,023.0	8,011,177.0	96.7
210803	Даатгалын үйлчилгээ	300,000.0	100,000.0	200,000.0	33.3
210804	Тээврийн хэрэгслийн татвар	300,000.0	249,748.0	50,252.0	83.2
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	120,000.0	00.0	120,000.0	00.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,500,000.0	3,924,000.0	576,000.0	87.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	198,640,000.0	188,661,998.0	9,978,002.0	95.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	195,640,000.0	185,828,398.0	9,811,602.0	95.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,000,000.0	2,833,600.0	166,400.0	94.5
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	48,062,000.0	35,809,837.0	12,252,163.0	74.5
2132	Бусад урсгал шилжүүлэг	48,062,000.0	35,809,837.0	12,252,163.0	74.5
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	28,421,000.0	16,737,312.0	11,683,688.0	58.9
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	19,641,000.0	19,072,525.0	568,475.0	97.1
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,293,276,100.0	1,240,569,746.8	52,706,353.2	95.9
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,293,276,100.0	1,240,569,746.8	52,706,353.2	95.9
132001	Орон нутгийн төсвөөс	1,293,276,100.0	1,240,569,746.8	52,706,353.2	95.9
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	46.00	46.00	00.00	100.0
620001	Удирдах ажилтан	17.00	17.00	00.00	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	22.00	22.00	00.00	100.0
620003	Үйлчлэх ажилтан	07.00	07.00	00.00	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл / төгрөгөөр /
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	92,785,363.37
21	УРСГАЛ ЗАРДАЛ	92,785,363.37
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	22,361,440.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	22,361,440.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	22,361,440.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	70,423,923.37
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,150,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,150,000.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	66,273,923.37
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	66,273,923.37
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	92,786,363.37
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	92,786,363.37
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,331,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	88,455,363.37
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)-(II)-(I)	00.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00

3. Аудитын тайлан

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Мөрөн сумын Засаг даргын Тамгын газар нь стратегийн төлөвлөгөө, бодлогын удирдамжийн хэрэгжилт, хөтөлбөр, төслийн биелэлт зэргийг сумын Засаг даргын дэргэдэх тасаг, алба, албан байгууллага, аж ахуйн нэгжид хэрхэн хэрэгжиж байгааг хянах, шалгах, зохицуулах, чиглэл өгөх, мэдээлэл авах зэрэг эрхтэйгээс гадна дээрх байгууллагаар дамжуулан мэдээллийг цуглуулж хяналт шинжилгээ хийх дүгнэлт гаргах үүрэгтэй ажилладаг орон нутгийн төсвийн байгууллага юм.

Мөрөн сум нь 2022 оныг “Ээлтэй Мөрөн” хөтөлбөрийг хэрэгжүүлэх жил болгон зарласан байна.

3.2 Байгууллагын гадаад дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчны талаар: Тус байгууллага нь Төсвийн тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хууль, нийгмийн даатгалын шимтгэлийн тухай хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль болон бусад хууль тогтоомж журам зааврын мөрдөн ажилласан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

Тайлант онд сумын Засаг даргын дэргэдэх орон тооны бус дотоод аудитын нэгж тус байгууллагад дотоод хяналтын нэгж хэрэгжүүлж ажилласан ба Засаг даргын Тамгын газрын даргын 2022 оны А/64 тушаалаар байгууллагын дотоод хяналтын нэгжийг шинээр байгуулсан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хөвсгөл аймгийн Мөрөн сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж Төсвийн тухай хуулийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдлийн дагуу бэлтгэж толилуулсан байна гэж үзлээ.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.5 дахь заалтын дагуу иж бүрэн гаргаж ирүүлсэн.

Санхүү нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа Хөвсгөл аймгийн Засаг даргын 2019 оны А/375 захирамжаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг үйл ажиллагаандаа ашиглаж байна. Тус нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт тусгагдсан зарим журам заавар шинэчлэгдсэн, боловсрол соёлын салбарын байгууллагуудын төсвийн шатлалд өөрчлөлт орсонтой холбоотой нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг өөрийн байгууллагын үйл ажиллагаандаа тохируулан боловсруулах шаардлага тулгарч байна. Санхүү төсөв нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа УСНББОУС, Засгийн газар, Сангийн яамнаас гаргасан журам, зааврыг мөрдөж ажилласан байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Мөрөн сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,271.7 сая төгрөгөөр буюу 5 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөг/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	33,294.1	66,274.9	32,980.8
Бараа материал	82,065.4	109,473.2	27,407.9
Биет хөрөнгө	22,224,312.2	20,898,556.5	-1,325,755.7
Биет бус хөрөнгө	2,161,383.7	2,155,016.2	-6,367.5
Нийт хөрөнгө	24,501,055.4	23,229,320.9	-1,271,734.5
Хуримтлагдсан үр дүн	21,530,010.8	20,258,276.3	-1,271,734.5
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	24,501,055.4	23,229,320.9	-1,271,734.5

Нэмэлт санхүүжилтийн данснаас 66,274.9 мянган төгрөгийг төвлөрүүлж авлага үүсгэсэн байна.

Бараа материалын данс 27,407.9 мянган төгрөгөөр өссөн нь Мөрөн Герман хамтын ажиллагааны сангаас хог хаягдлыг ангилан ялгах хөтөлбөрийн хүрээнд бэлтгэсэн материал 9,000.0 мянган төгрөг, бусад хангамжийн материалд орлого авсан шагнал, тэмдэг, медаль 10,400.0 мянган төгрөгөөр, хашаандаа сайхан амьдаръя төслийн хүрээнд хийгдсэн макет зураг төсөв 8,000.0 сая төгрөгөөр орлого авсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн дүн өмнөх оноос 1,325,755.7 мянган төгрөгөөр буурсан байна. Үүнд:

- Тайлант онд төсвийн хөрөнгөөр 870.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан.
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 335,399.5 мянган төгрөгийн хөрөнгө
- 62,513.6 мянган төгрөгийн хөрөнгийг сумын орон нутгийн хөрөнгө оруулалтаар
- Аймгийн орон нутгийн хөрөнгө оруулалтаар 423,337.6 мянган төгрөг
- 44,840.0 мянган төгрөгийн хөрөнгийг орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр бэлтгэж орлого авсан байна.
- Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 178,973.7 мянган төгрөгийн хөрөнгийг 86,039.8 мянган төгрөгөөр дахин үнэ тогтоож байгууллагын өмч хамгаалах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж бүртгэсэн байна.
- Аймгийн ИТХ-ын 2022 оны А/92 дугаар тогтоолоор 2,318.0 мянган төгрөгийн хөрөнгийг акталсан байна.

Хуримтлагдсан үр дүн 1,271,734.5 мянган төгрөгөөр буурсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд 1,440,054.9 мянган төгрөгийн зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төсөвлөж дээд шатны төсөв захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 289,704.9 мянган төгрөгөөр бууруулж, 1,150,350.0 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 172,630.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 10 арга хэмжээг хэрэгжүүлэхээр 1,293,276.1 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,240,569.7 мянган төгрөг буюу 95.9 хувьтай байгаа ба 52,706.4 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлжээ.

Хүснэгт 1. Хөтөлбөр, арга хэмжээний зардал

/мянган төгрөгөөр/

Хөтөлбөр, арга хэмжээ	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
70106	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	1,278,161.80	1,225,546.70	52,615.10	95.9
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	534,617.50	517,700.70	16,916.80	96.8
80106	Баг, хорооны үйл ажиллагааны зардал	188,687.50	184,062.40	4,625.10	97.5
80112	Нийтлэг үйлчилгээ	91,754.80	88,693.40	3,061.40	96.7
80205	Мэдээлэл, сурталчилгааны зардал	7,400.00	5,800.50	1,599.50	78.4
80305	Биеийн тамирын уралдаан, тэмцээн	2,000.00	1,638.00	362.00	81.9
80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж,	19,641.00	19,072.50	568.50	97.1
80815	Сонгуулийн үр дүнгээр чөлөөлөгдсөн албан хаагчид олгох нөхөн олговор	28,421.00	16,737.30	11,683.70	58.9
81518	Мөрийн хөтөлбөрт тусгагдсан зарим арга хэмжээг санхүүжүүлэх	322,640.00	310,146.50	12,493.50	96.1
81102	Орон нутгийн нөөц хөрөнгө	83,000.00	81,695.40	1,304.60	98.4
71413	Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх	15,114.30	15,023.00	91.30	99.4
81701	Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх	15,114.30	15,023.00	91.30	99.4
НИЙТ		1,293,276.10	1,240,569.70	52,706.40	95.9

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд дараах орлогууд орсон байна. Үүнд:

- Өмнөх оны үлдэгдэл 32,796.7 мянган төгрөг
- Баяр наадмын үеэр олгосон зөвшөөрлийн орлого 11,076.0 мянган төгрөг
- Илч түлш аяны түлээний орлого 27,396.8 мянган төгрөг
- Өвс тэжээлийн орлого 3,936.0 мянган төгрөг
- Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газраас хамтарсан багийн зардалд 1,131.0 мянган төгрөг,
- Аймгийн Засаг даргын Тамгын газраас намрын ногоон өдрүүд үзэсгэлэнгийн шагнал 900.0 мянган төгрөг, Шилдэг сум IV байрын шагналд 800.0 мянган төгрөг
- Аймгийн ИТХ-аас хамтарсан багийн зардалд 4,500.0 мянган төгрөг,
- Мөрөн вилла ХХК-аас зам сэтэлсний барьцаа 5,040.0 мянган төгрөг,

- Шүүхийн шийдвэрээр хураагдсан эд зүйлсийн орлого 1,410.0 мянган төгрөг
- Биеийн тамир спортын газраас нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх арга хэмжээний шагналд 1,500.0 мянган төгрөг
- Түрээсийн орлого 2,299.9 мянган төгрөгийн орлогыг тус тус авсан байна.

Нэмэлт санхүүжилтийн данснаас зохих журмын дагуу эрхийг нээлгэж, зарцуулалтыг хийсэн ба 66,274.9 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Мэргэжлийн хяналтын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Г.Ичинхорлоо гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Б.Давааням, аудитын менежер Б.Тэгшдэлгэр, дарга, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Мөрөн сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны 03/69 албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 3,506,407.7 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 70.1 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 буюу 56.1 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага Тэргүүн дэд, дэд, орлогч дарга, тээврийн хэрэгсэл, албан тасалгаа, дүрэмт хувцас, албан томилот, нэг удаагийн мөнгөн тэтгэмж, бусад хангамж, цахим худалдан авалт, Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд хориглосон зарим асуудал, Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн авч хэрэгжүүлэх арга хэмжээний нийт 29 асуудлаар хяналтыг сорилыг хэрэгжүүллээ. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотойгоор дараах зөрчлүүд илэрсэн болно.

1. Төсвийн хөрөнгөөр сумын Тэргүүний тэмдэг, сумын хүндэт тэмдэг, жуух бичиг, тууз гэсэн 11,280,000.0 төгрөгийн үнэ бүхий зүйлсийг нөөцөлсөн байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1.6."нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх" гэсэн заалттай нийцэхгүй байна.

2. Багийн засаг дарга нар багт ажиллахаар 4,156,950.0 төгрөгийн шатахууныг зарцуулсан байгаа нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь заалттай нийцэхгүй байна.

Дээрх зөрчилд албан шаардлага өгөхөөр шийдвэрлэлээ.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Байгууллагын 2022 оны санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийн асуудлыг авч үзсэн бөгөөд аудитын санал дүгнэлтэд хамруулан үзээгүй болно.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 2022 онд мэдээллийг бүрэн оруулж ажилласан байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Эзэмших эрх бүхий 172,112 м.кв хэмжээтэй 2,142,291.0 мянган төгрөгийн газар нь байгууллагын дүрмийн санд бүртгэлгүй байгаа нь Сангийн сайдын 2018 оны 207 дугаар тушаалаар батлагдсан "Үл хөдлөх хөрөнгийн үнэлгээ, бүртгэлийг нягтлан бодох бүртгэлийн дансанд тусгах аргачлал" - ийн 5.5 дахь заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэлт:

Байгууллагын дүрмийн санд бүртгэж залруулахаар шийдвэрлэлээ.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Хөвсгөл аймгийн Мөрөн сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны II улирлын санхүүгийн тайланд завсрын аудит хийж 2 зөвлөмжийг өгсөн байна. Завсрын аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлэн ажиллаж алдаа зөрчлийг арилгасан байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар байгууллагын тооцооны үлдэгдлийг баталгаажуулах, шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах талаар 3 зөвлөмжийг өгч, тайлант онд хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	3	52,5000	3	100	100
Нийт дүн	3	52,5000	3	100	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар онцгойлон үзэх асуудал байхгүй байна.

5. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 2,153,178.3 мянган төгрөгийн алдааг илрүүлж аудитын хугацаанд бүрэн залруулсан. Үүнд:

1. Байгууллагын эзэмших эрхтэй 2,142,291.0 мянган төгрөгийн газрыг дүрмийн санд бүртгэлгүй байсныг залрууллаа.
2. Төсвийн гүйцэтгэлийн тайланд 10,887.3 мянган төгрөгийн төсвийн тохируулга хийгээгүй байсныг залрууллаа.

5.2 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогоогүй болно.

5.3 Албан шаардлага

1. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт:

Төсвийн хөрөнгөөр сумын Тэргүүний тэмдэг, сумын хүндэт тэмдэг, жуух бичиг, тууз гэсэн 11,280,000.0 төгрөгийн үнэ бүхий зүйлсийг нөөцөлсөн байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1.6."нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх" гэсэн заалттай, Багийн засаг дарга нар багт ажиллахаар 4,156,950.0 төгрөгийн шатахууныг зарцуулсан байгаа нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 "Энэ хуулийн 3.1-д заасан этгээд орон нутагт албан томилолтоор, хуульд заасан эрх бүхий этгээд газар дээрх хяналт шалгалтаар ажиллахад хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, эсхүл төрийн болон орон нутгийн өмчийн авто тээврийн байгууллагаар үйлчлүүлэхээс бусад тохиолдолд автомашин ашиглахыг хориглоно" гэсэн заалттай тус тус нийцэхгүй байна.

1.2 Өгсөн албан шаардлага:

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах

5.4 Зөвлөмж

Зөвлөмж өгөөгүй болно.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/ мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Газрын бүртгэлийг буруу бүртгэсэн	1	2,142,291.0			1	2,142,291.0	1	2,142,291.0				
Төсвийн гүйцэтгэлийн тайланг алдаатай илэрхийлсэн	1	10,887.3			1	10,887.3	1	10,887.3				
Дүн	2	2,153,178.3			2	2,153,178.3	2	2,153,178.3				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил	Үүнээс				
		Төлбөрийн акт	Албан шаардлага	Зөвлөмж	Хариуцлага тооцуулах албан шаардлага	Хууль, хяналтын байгууллагад

Мөрөн сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

											шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой	1	15,936.5			1	15,936.5						
Дүн	1	15,936.5			1	15,936.5						

АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

АХЛАХ АУДИТОР

БАТАЛГААЖУУЛСАН:

АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР ОГНОО:

Б.ТЭГШДЭЛГЭР ОГНОО:

Б.ДАВААНЯМ ОГНОО:

Г.ИЧИНХОРЛОО ОГНОО:



5/17

2/16



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 08 сарын 24 өдөр

№ 19/АЭЭТД0648/ХАА - 2023/104
МН - СТА - ТШЗ

Мөрөн сум

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Мөрөн сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Мөрөн сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны батлагдсан төсвөөс сумын Тэргүүний тэмдэг, сумын хүндэт тэмдэг, жуух бичиг, тууз зэрэг 11,280,000.0 (арван нэгэн сая хоёр зуун наян мянга) төгрөгийн үнэ бүхий зүйлсийг худалдан авч нөөцөлсөн байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1.6."нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх" гэсэн заалттай,

2. Мөрөн сумын Багийн засаг дарга нар багт ажиллахаар 4,156,950.0 (дөрвөн сая нэг зуун тавин зургаан мянга есөн зуун тавин) төгрөгийн шатахууныг зарцуулсан байгаа нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 "Энэ хуулийн 3.1-д заасан этгээд орон нутагт албан томилолтоор, хуульд заасан эрх бүхий этгээд газар дээрх хяналт шалгалтаар ажиллахад хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, эсхүл төрийн болон орон нутгийн өмчийн авто тээврийн байгууллагаар үйлчлүүлэхээс бусад тохиолдолд автомашин ашиглахыг хориглоно" гэсэн заалттай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, акт тогтоох журмын 4.2.1.11-т "Хууль, тогтоомж, гэрээ, хэлцэл, зөрчсөн алдаа зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал нь албан шаардлага өгөх нөхцөл болно" гэж заасныг тус тус үндэслэн

ШААРДАХ нь:

- Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллаагүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2023 оны 9 дүгээр сарын 01-ны дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт¹ ирүүлэх;
- Цаашид гарсан алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллахыг Мөрөн сумын Засаг даргын Тамгын газрын дарга Г.Нэргүй, нягтлан бодогч Т.Алтантуяа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

АУДИТОР:

А.ЭРДЭНЭБААТАР

Г.ИЧИНХОРЛОО

¹ Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 8-р баг, Хөвсгөл аймгийн ЗДТГ-ын байрны 3 дугаар давхар, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын 302, тоот Утас: 70384043